



ХЭНТИЙ АЙМАГ
БОР-ӨНДӨР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 12

Бор-Өндөр

Сумын Засаг даргын 2025-2028 оны үйл
ажиллагааны хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.5 дахь заалт, Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хоёрдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Бор-Өндөр сумын Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрийн санхүүжилтийг сумын төсөвт тусгаж, хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулж, дүнг жил бүр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж ажиллахыг Засаг дарга (Г.Адъяабилэгт)-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүний хөгжил, нийгмийн бодлогын хороон дарга (О.Мөнгөнтуул)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Э.МОНХ-ЭРДЭНЭ



Бор-Өндөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны хоёрдугаар хуралдааны
дүгээр тогтоолын хавсралт

Бор-Өндөр сумын Засаг даргын 2025-2028 оны
үйл ажиллагааны хөтөлбөр

1822030035 4189736

НЭГ. БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж, иргэдэд таатай, эрүүл, аюулгүй, байгаль орчинд ээлтэй төвүүдийг хөгжүүлнэ.

1.1. БҮСИЙН ХӨГЖИЛ

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг дэмжинэ.

1.1.1. Аж үйлдвэрийн бүс нутаг болох суурийг тавьж ачилт тээвэрлэлтийн дэд бүтцийг хөгжүүлнэ.

1.1.2. Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулан батлуулж, аж үйлдвэр, жижиг дунд үйлдвэрлэлд түшиглэсэн сүм болгон хөгжүүлнэ.

ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Эдийн засгийн өсөлтийг өрх бүрт хүргэж, ая тухтай амьдрах орчныг бүрдүүлж, эрүүл чийрэг, эрдэм боловсролтой иргэнийг төлөвшүүлнэ.

2.1 ГЭР БҮЛ

Гэр бүл, хүүхэд, залуучуудын нийгмийн оролцоог нэмэгдүүлж, гэр бүл нийгмийн орчин дахь хүүхэд хамгааллыг сайжруулна.

2.1.1. Гэр бүлийн хүчирхийллийг бууруулж, хүчирхийллийг үл тэвчих нөлөөллийн арга хэмжээг эрчимжүүлэн, хөгжлийн үйлчилгээг хамтарсан багаар гүйцэтгүүлэн, сэтгэл зүйн үйлчилгээг үзүүлнэ.

2.1.2. Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын "Ирээдүйн эзэд" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах **АЗДУАХ 2.1.1.1**

2.1.3. Засгийн газраас хэрэгжүүлж буй өсвөр үе, залуучуудын хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлнэ. **АЗДУАХ 2.1.1.2**

2.1.4 Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ. **АЗДУАХ 2.1.1.3**

2.2 Хөдөлмөр халамж, нийгмийн даатгал

Ажлын байрыг нэмэгдүүлж, тэгш боломжийг бүрдүүлж, сайн дурын даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлнэ.

2.2.1. Нийгмийн халамжийн зорилтот өрхийн хөдөлмөрийн чадвартай иргэдийг хөдөлмөр эрхлэх боломжоор хангана. **АЗДУАХ 2.1.2.1**

2.2.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан, зорилтод бүлгийн иргэдийг хувийн хэвшил, төрийн бус байгууллагуудын оролцоотойгоор дэмжин ажиллана. **АЗДУАХ 2.1.2.2**

2.2.3. Бүтээн байгуулалтын томоохон тесел хетелберүүдийн үр дүнд байнгын болон түр ажлын байраар хангана. **АЗДУАХ 2.1.2.3**

2.2.4. Тусгай хэрэгцээ шаардлагатай иргэдэд зориулсан орчны хүртээмжийг нэмэгдүүлж, мэдээлэл авах тэгш боломжоор хангана.

2.2.5. Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж, үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлнэ. **АЗДУАХ 2.1.2.5**

2.2.6. Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч, ажилгүй иргэн, даатгуулагчдад нийгмийн даатгалын үйлчилгээг чанартай, хүртээмжтэй үзүүлнэ. **АЗДУАХ 2.1.4.1**

2.3 Биеийн тамир, спорт

Биеийн тамираар хичээллэгсдийн тоог нэмэгдүүлж, орчны хүртээмжийг сайжруулна.

2.3.1. Залуучуудын сургалт, спорт хөгжлийн төвийг барина.

2.3.2. Иргэдийг идэвхтэй хөдөлгөөн хийх нөхцөл боломжоор хангаж, нийтийн биеийн тамир, үндэсний спорт болон их спортоор хичээллэгсдийн тоог нэмэгдүүлнэ. **АЗДУАХ 2.1.5.3**

2.3.3. Өсвөр болон насанд хүрэгчдийн шигшээ багийн тамирчдыг дэмжин, тамирчдын гаргасан амжилтыг ахиулна. **АЗДУАХ 2.1.5.2**

2.4. Боловсрол

Хүүхэд бүрийг хөгжүүлж, сурах орчин нөхцөлийг сайжруулж, сургалтын чанарыг нэмэгдүүлнэ.

2.4.1. Бүх шатны боловсролын байгууллагын чанар хүртээмжийг сайжруулж, боловсролд тэгш хамруулан, бүлэг дүүргэлтийг стандартын түвшинд хүргэнэ. **АЗДУАХ 2.2.1.1**

2.4.2. Боловсролын салбарын багш, ажилтан албан хаагчдын санал санаачилгыг бүрэн дэмжиж, нийгмийн баталгааг ханган ажиллана. **АЗДУАХ 2.2.1.3**

2.4.3. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт шаардлагад нийцсэн тэгш боломж бүхий мэргэжлийн боловсролыг хөгжүүлнэ. **АЗДУАХ 2.2.1.4**

2.4.4. ЕБС, дотуур байр, СӨБ-ийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чанар стандартыг сайжруулна. **АЗДУАХ 2.2.1.5**

2.4.5. Боловсролын салбарын барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан, стандарт, чанарын шаардлага хангасан орчныг бүрдүүлэн зориулалтын тоног төхөөрөмжөөр хангана. **АЗДУАХ 2.2.1.6**

2.4.6. Иргэний ёс суртахуун, төлөвшил, амьдрах ухаан, гэр булийн боловсрол олгох үйл ажиллагааг дэмжиж, насан туршийн боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.5. Эрүүл мэнд

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, эрүүл амьдралын хэв маягтай иргэнийг төлөвшүүлнэ.

2.5.1. Эрүүл амьдралын хэв маягийг дэмжсэн дасгал хөдөлгөөн, спорт, нийтийн биеийн тамираар хичээллэх, эрүүл зөв хооллох, өвчинөөс урьдчилсан сэргийлэх, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлнэ. **АЗДУАХ 2.3.1.1**

2.5.2. Эрүүл мэндийн байгууллагуудыг барилга, тоног төхөөрөмжөөр хангаж ажиллана. **АЗДУАХ 2.3.1.7**

2.5.3. Эх хүүхдийн эрүүл мэндийг дэмжиж, 0-5 насны хүүхдийн өвчлөлийг буруулж, сэргийлж болох нярайн эндэгдлийг багасгана. **АЗДУАХ 2.3.1.2**

2.5.4. Цахим эрүүл мэндийн аюулгүй байдлыг хангаж дэвшилтэт технологи телемедицин (зайн оншилгоо)-г нэвтрүүлэх

2.5.5. Эмч, мэргэжилтнүүдийн санал санаачилгыг бүрэн дэмжиж, нийгмийн баталгааг ханган ажиллана. **АЗДУАХ 2.3.1.6**

2.6. Орон сууц, дэд бүтэц

Орон сууц барих санаачилгыг дэмжиж, иргэдийг ая тухтай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

2.6.1. Төрийн албан хаагчид, залуучууд, орлого багатай иргэдийг түрээсийн орон сууцаар хангана. **АЗДУАХ 2.4.1.1**

2.6.2. Төр хувийн хэвшлийн түншлэлээр хөнгөлөлттэй орон сууцаар төрийн албан хаагч, иргэдийг хангана. **АЗДУАХ 2.4.1.2**

2.6.3. Барилга байгууламжид техникийн хяналтыг хийлгүүлж, барилга байгууламжийн чанарыг дээшлүүлнэ. **АЗДУАХ 2.4.1.4**

2.6.4. Гэр хорооллыг инженерийн шугам сүлжээнд холбох ажлыг эхлүүлж, инженерийн шугам сүлжээний найдвартай ажиллагааг хангана. **АЗДУАХ 2.4.2.1**

2.6.5. Иргэдийг тав тухтай, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж, сумын дэд бүтцийг сайжруулж, шат дараатайгаар шинэчилнэ.

ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

Төсөв, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг сайжруулан, төр, хувийн хэвшлийн түншлэлийн эдийн засгийг бэхжүүлнэ.

3.1. Төсөв, санхүү

Төсвийн хөрөнгийг зүй зохистой, үр ашигтай зарцуулах, эрсдэлийг бууруулахад чиглэсэн хяналтыг тавьж ажиллана.

3.1.1 Төсөв санхүүгийн ил тод байдлын хэрэгжилтийг шилэн дансны цахим худсаар хангаж ажиллана. **АЗДУАХ 3.1.1.1**

3.1.2. Санхүүгийн ажилтнуудыг чадавхжуулж, санхүүгийн сахилга батыг сайжруулж, төрийн аудитаар илэрдэг зөрчлийг бууруулна. **АЗДУАХ 3.1.1.2**

3.1.3. Хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийг сайжруулж, хоршоо хөгжүүлэх сангийн журмын дагуу зээлийг олгоно. **АЗДУАХ 3.1.1.3**

3.1.4. Татварын тогтолцоог сайжруулан, аж ахуйн нэгжүүд хуулийн дагуу төлсөн татварыг буцаан олгох, хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх боломжийг олгоно. **АЗДУАХ 3.1.2.3**

3.1.5. Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, бүртгэл, хяналтыг сайжруулна. **АЗДУАХ 3.1.3.1**

3.1.6. Худалдан авах ажиллагаа зохион байгуулах ажилтан, албан тушаалтан, иргэн, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг сургалтад хамруулж мэргэшсэн албан хаагч, иргэдийн тоог нэмэгдүүлнэ. **АЗДУАХ 3.1.4.1**

3.1.7. Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан дотоодын үйлдвэрлэлийг дэмжиж ажиллана. **АЗДУАХ 3.1.4.2**

3.2. Төрөлжсөн эдийн засаг

Томоохон төслүүдийг дэмжин, хамтран ажиллана.

3.2.1. Бор-Өндөр- Дархан- Баянмөнх- Чингис хот чиглэлийн хатуу хучилттай авто замыг барьж ашиглалтад оруулна. **АЗДУАХ 3.2.2.2**

3.2.2. Шинэ суурьшлын бүсэд цахилгаан дамжуулах шугам татах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. **АЗДУАХ 3.2.3.1**

3.3. Хөдөө аж ахуй

Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэх хоршоодыг дэмжих замаар хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хүн амыг эрүүл аюулгүй хүнсээр хангах, малын эрүүл мэндийг хамгаалах, малын ашиг шим, үүлдэр угсааг сайжруулна.

3.3.1. Малын гаралтай түүхий эд бэлтгэх, боловсруулах үйлдвэрлэл эрхлэх хоршоодод дэмжлэг үзүүлнэ. **АЗДУАХ 3.2.4.1**

3.3.2. Мал амьтны гаралтай арьс, шир, ноосыг боловсруулж, оёмол, сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх төсөл хөтөлбөрийг дэмжинэ. **АЗДУАХ 3.2.4.2**

3.3.3. Төмс, хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлэн, хүлэмж, зоорь, хүнсний ногооны үрийн хангамжийг сайжруулж, дотоодын хэрэгцээг хангана. **АЗДУАХ 3.2.5.2**

3.3.4. Бэлчээр хамгаалалт, ашиглалтыг сайжруулан, евс тэжээлийн неец бүрдүүлэлт, усан хангамжийг нэмэгдүүлнэ. **АЗДУАХ 3.2.6.3**

3.3.5. Малын чанар, ашиг шимийг сайжруулж, эрчимжсэн мал аж ахуй, шинэ залуу малчин, малжуулах төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг хангана. **АЗДУАХ 3.2.6.1**

3.3.6. Баялаг бүтээгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд таниулах, ашиг орлого олох боломжийг бүрдүүлэн, бүх талаар нь дэмжих бодлогыг хэрэгжүүлнэ. **АЗДУАХ 3.2.4.2**

3.3.7. Мал эмнэлгийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх, малын гаралтай халдварт, гоц халдварт өвчний гаралтыг бууруулах, өвчний хяналт, сэргийлэлт, яаралтай хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангана. **АЗДУАХ 3.2.7**

3.2.8. Туслах аж ахуй эрхлэгчийн үйл ажиллагааг бүх талаар нь дэмжинэ. **АЗДУАХ 3.2.4.2**

3.4. Соёл урлаг

Соёлын үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна

3.4.1. Аймаг, орон нутгаас төрөн гарсан урлаг, соёлын алдартнуудын уран бүтээлийг сурталчилж, түгээн дэлгэрүүлнэ. **АЗДУАХ 3.3.1.2**

3.4.2. Соёлын өвийг сурталчилж, хадгалалт, хамгаалалтыг сайжруулна. **АЗДУАХ 3.3.1.3**

3.4.3 Соёлын төвийн орчин нөхцөлийг сайжруулах, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, соёлын үйл ажиллагааг дэмжинэ.

3.4.4. Соёлын үйлчилгээний тоо, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн, соёлын бодлого, шийдвэр гаргах үйл явцад уран бүтээлчид, аж ахуйн нэгжүүд цахимаар оролцох боломжийг нээлттэй болгоно.

3.5. Ногоон хөгжил

Уул уурхайн нөхөн сэргээлтийг нэмэгдүүлж, хог хаягдлын менежментийг сайжруулж, ногоон байгууламжийн тоог нэмэгдүүлнэ.

3.5.1 Хог хаягдлын цогц менежментийг хэрэгжүүлж, эдийн засгийн үр өөжийг нэмэгдүүлэн, хог хаягдлын зориулалтын байгууламжтай болно. **АЗДУАХ 3.4.5.1**

3.5.2. Уул уурхайн нөлөөгөөр эвдрэлд орсон, бохирдсон газрыг нөхөн сэргээх, газрын доройтол, цэлжилтээс сэргийлж, хөрсний үржил шимийтг нэмэгдүүлэхэд шинэ дэвшилтэт арга замыг тодорхойлж хэрэгжүүлнэ. **АЗДУАХ 3.3.1.4**

3.5.3. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг ханган ажиллана. **АЗДУАХ 3.3.2.1**

3.5.4. Уул уурхайд үйлдвэрлэлийн технологид хэрэглэсэн усыг дахин ашиглах, саарал ус нийлүүлэх төслийг дэмжинэ. **АЗДУАХ 3.4.5.1**

ДЕРӨВ. ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЭЛСЭН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

Төрийн цахим шилжилт, үйлчилгээг эрчимжүүлэн, үр ашиг, хүртээмж, ил тод байдлыг нэмэгдүүлэн, чадварлаг төрийн албыг төлөвшүүлж, хүний эрхийг дээдэлсэн, авлигагүй төрийн бодлогыг хэрэгжүүлж, эх оронч сэтгэлгээг бий болгож, гамшигтай тэмцэх чадавхыг нэмэгдүүлнэ.

4.1. Хууль эрх зүй

Нийгмийн дэг журам, аюулгүй байдлыг хангаж, гэмт хэрэг гаралтыг бууруулна.

4.1.1. Бүх нийтийн эрх зүйн боловсролын хүрээнд хууль тогтоомжийн мэдлэгийг нэмэгдүүлэн, сурталчлан таниулна. **АЗДУАХ 4.1.1.1**

4.1.2. Архины хор хөнөөлөөс урьдчилан сэргийлж "Архидалтгүй Хэнтий" арга хэмжээний биелэлтийг хангана. **АЗДУАХ 4.1.1.2**

4.1.3. Архивын баримтын хадгалалт хамгаалалтыг сайжруулна. **АЗДУАХ 4.1.1.3**

4.1.4. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг шат дараатайгаар зохион байгуулж, нийтийн хэв журам, аюулгүй байдлыг хангах тал дээр дэмжлэг үзүүлнэ. **АЗДУАХ 4.1.1.4**

4.1.5. "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг орон нутгийн онцлогт тохируулан зохион байгуулна. **АЗДУАХ 4.2.1.1**

4.2. Төрийн алба

Төрийн албан хаагчдын ажлын бодит үнэлэмж, үр дүнг сайжруулж хяналт тавин, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

4.2.1. Төрийн албанда шаардлагатай байгаа мэргэжлээр суралцаж буй оюутанд сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлнэ.

4.2.2. "Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг хангаж ажиллана. **АЗДУАХ 4.3.1.2**

4.2.3. Төрийн байгууллагуудын үйлчилгээний стандартыг сайжруулж, мөрдлөг болгоно. **АЗДУАХ 4.3.1.3**

4.2.4. Төрийн албан хаагчдыг улс төрөөс ангид тогтвортой, ил тод ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлж, төрийн албан хаагч нь ажил үүргээ гүйцэтгэхдээ танил талдаа давуу тал олгохгүй байх зарчмыг хэвшүүлнэ.

4.2.5. Орон нутгийн засаглалд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх "Иргэдийн оролцоот-Нэг Хэнтий" арга хэмжээг хэрэгжүүлнэ. **АЗДУАХ 4.3.2.2**

4.2.6. Төрийн нууцад хамаарахаас бусад мэдээллийг олон нийтийн цахим сүлжээгээр нийтэд нээлттэй болгож, иргэдийн мэдэх, хяналт тавих нөхцөлийг нэмэгдүүлж, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг ил тод болгоно. **АЗДУАХ 4.3.2.3**

4.3. Цахим шилжилт

Төрийн үйлчилгээг ил тод нээлттэйгээр иргэдэд түргэн шуурхай хүргэх

4.3.1. Төрийн үйлчилгээний цахим системүүд болон E-Mongolia системийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. **АЗДУАХ 4.4.1.1**

4.3.2. Иргэд олон нийтийг кибер аюулгүй байдлын талаар мэдээ мэдээллээр хангаж, мэдлэгийг дээшлүүлнэ. **АЗДУАХ 4.4.2.1**

4.3.3. Төрийн байгууллагад мэдээлэл, харилцаа холбооны технологийн зохистой хэрэглээг нэвтрүүлж, байгууллага хооронд сайн туршлага хуваалцах, сурталчлах арга хэмжээг зохион байгуулна. **АЗДУАХ 4.4.2.2**

4.4. Орон нутгийн хамгаалалт

Орон нутагт батлан хамгаалах бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, сумын гамшигтай тэмцэх чадавхыг нэмэгдүүлнэ.

4.4.1. "Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний дагуу нөөц бүрдүүлэх, сэдэвчилсэн дадлага, сургалтад томилгоот нэгжийг хамруулна. **АЗДУАХ 4.7.1.1**

4.4.2. "Хүүхэд, залуучуудад цэрэг, эх оронч үзэл төлөвшүүлэх" арга хэмжээг зохион байгуулна. **АЗДУАХ 4.7.1.2**

4.4.3. Иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангаж, гамшигийн эрсдэлийг бууруулна. **АЗДУАХ 4.8.1.2**

4.4.4. Гамшигтай тэмцэх чадавхыг нэмэгдүүлнэ. **АЗДУАХ 4.8.1.3**

4.4.5. Гал түймэр унтраах, аврах ангийн 2 дугаар зэрэглэлийн барилгыг барина.